

**НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
/2016-2021 оны жилийн эцсийн байдлаар/

Д/д	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт		Зорилгод түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл, хувь Тайлбар /Хэрэгжээгүй шалтгаан/
				Он	Түвшин			
1.	МУНХБ 6. Уур амьсгалын өөрчлөлт, бус нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.	1.Нийслэлийн нийтийн тээвэрт "тусгай замын автобусны үйлчилгээ" (BRT)-г нэвтрүүлэх	64.5 км тусгай зам баригдаж, зорчигчдод шуурхай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.	2017			30%	2017-2019 онд "Нийслэлийн нийтийн тээврийн хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр" /BRT/ төслийн хүрээнд төслийн нэгж байгуулж, Ерөнхий төлөвлөгөө, Зургийн ажлын болон зөвлөх үйлчилгээний даалгавар боловсруулж, олон улсын сонгон шалгаруулалт зарласан боловч төслийн санхүүжилтийн хугацаа дуусч хийгдээгүй. Нийслэлийн засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдөр төслийн хаалтыг зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр зогсоох тухай А/374 дүгээр захирамж гарсан.
2.		2. Нийслэлийн нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийх, маршрут, зогсоолыг оновчтой, төлөвлөж хэрэгжүүлнэ.	Стандартын шаардлага хангасан, хаягдал багатай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зорчих боломжтой тээврийн хэрэгслийн тоо	2016			100%	1. 2018 онд дотооддоо угсарч үйлдвэрлэсэн "МОН-30" загварын их багтаамжийн 2 цахилгаан автобусаар 2019 онд NAMJING маркийн их багтаамжийн 1 цахилгаан автобусаар 2020 онд GTQ616BEVT20 маркийн 8 ширхэг цахилгаан автобус, NJL6100GSEV маркийн 2 давхар цахилгаан автобусаар тус тус парк шинэчилсэн. 2021 онд "Цахилгаан автобусаар парк шинэчлэлт хийх" төслийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкнаас төслийн зээлээр 2021 оны 5 сард Хятад улсад 2021 онд үйлдвэрлэсэн Skuwell загварын их багтаамжийн 35 ширхэг цахилгаан автобусаар парк шинэчлэлт хийж 2021.06.08-ны өдрөөс "Зорчигч тээвэр гурав"ОНӨААТҮГ-ын үйлчилгээ үзүүлдэг нийтийн тээврийн үйлчилгээний Ч:1 "5шар-Офицеруудын ордон", Ч:29"Сэлбэ амралт-Вокзал", Ч:59 "ХМК- Офицеруудын ордон" болон хот орчмын ХО:5 "Налайх- Офицеруудын ордон" гэсэн 4 чиглэлд өдөр бүр 2000 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Мөн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний

<p>газраас 2021.04.12 өдөр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шинээр худалдан авах автобусны техникийн үзүүлэлтүүдийг стандартын шаардлагыг хангасан байхаар тусгаж 2/409 тоот албан бичгээр хүргүүлсний дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2021.04.16-ны өдөр Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд 60 шинэ автобус худалдан авах тендер зарлаж 2021.09.14-ний өдөр "Сүлдэрхан минералс" ХХК болон "Хиа теп golden dragon bus" Co.,Ltd түншлэлийн ирүүлсэн тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн гэж үзсэн. Үүний дагуу 2021 оны 12 сард сүүлийн хугацаа 2022 оны 1 сард багтаан их багтаамжийн 60 автобусыг нийлүүлэх гэрээ байгуулсан. Үүний дагуу тус газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08 –ны өдрийн А/64 дүгээр тушаалаар 8 хүний бүрэлдэхүүнтэй захиалагчийн хяналт тавих, хүлээн авах ажлын хэсэг байгуулагдан "Сүлдэрхан минералс" ХХК –иас нийлүүлэгдэх их багтаамжийн автобусны техникийн үзүүлэлт, тодорхойлолтод тодруулга хийж уулзалт зохион байгуулан захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2. 2016 онд иргэдийн зорчих эрэлтэд нийцүүлэн 4 чиглэлийн замналд өөрчлөлт оруулан давхцан үйлчилж буй 2 чиглэлийг нэгтгэсэн.</p> <p>2017 онд нийтийн тээврийн үйлчилгээний 3 чиглэлийг богиносгон богино эргэлтийн 2 чиглэлийг шинээр нээсэн.</p> <p>2018 онд иргэдийн зорчих эрэлтэд үндэслэн нийт 11 чиглэлд өөрчлөлт оруулж, 2 чиглэлийг шинээр нээсэн байна.</p> <p>2019 онд иргэдийн эрэлтэд нийцүүлэн 5 чиглэлийн замналд өөрчлөлт оруулж, 3 экпрес, 1 богино эргэлтийн чиглэл шинээр нээсэн. Нисэх, Баянхошуу, Чингэлтэй чиглэлийн замналд өөрчлөлт оруулан богино эргэлтээр явуулж эдгээр чиглэлд иргэдийн автобус хүлээгдлийн хугацааг 3-7 минутгаар бууруулсан.</p> <p>2020 онд үндсэн 7 чиглэлд өөрчлөлт оруулж, буухиа үйлчилгээний 2 чиглэлийг шинээр нээж</p>										
---	--	--	--	--	--	--	--	--	--	--

						70%	<p>үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний ажил, Нийслэлийн авто замын газар болон Бүгд найрамдах Франц улсын хөрөнгө оруулалттай "Жэй Си Дэко Монголиа" ХХК-тай 2015 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, 242 байршилд дэлхийн стандартад нийцсэн автобусны зогсоол барих төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлж байна. Энэхүү гэрээний дагуу 2019 он хүртэл 211 зогсоолын байгууламжийг тохижуулсан. 2020 онд 31 зогсоолыг тохижуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэгч компанийн хөрөнгө оруулалт, ковид-19 цар тахлаас шалтгаалан хойшлогдсон.</p> <p>3. Тус газрын бүртгэлийн санд 1263 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 57 тээврийн хэрэгсэл буюу 4.51% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэхээр тоноглогдсон, 1263 тээврийн хэрэгслүүд 100% хяналтын камертай, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан чиглэлийн болон зогсоолын нэр заасан урсдаг самбартай, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоол зарлагатай байна</p>
3.	3. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд халгүй тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх туршилт хийж нэвтрүүлэх	Нийтийн тээврийн үйлчилгээ орчинд халгүй байх туршилт, судалгаа хэрэгжүүлэх төлөвлөлт хийгдсэн байна.	2016				<p>2020.07.31-ний өдөр НИТХ-ын 126 дугаар тогтоолоор Дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл хэрэгжихтэй холбогдуулан "Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ байгуулагдсан. Хоёр орны засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн дагуу гэрээг баталгаажуулж Сангийн яам, НЗДТГ-ын зөвшөөрлөөр БНФУ-ын Төрийн сангийн банк-аас гэрээний урьдчилгаа төлбөр 20%-ийн төлбөрийг төслийн гүйцэтгэгч нар 2020.09.11-нд олгосноор Монгол улсын засгийн газрын зээлийн хүү тооцогдон төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн.</p> <p>Мөн 2021.09.20-ны өдөр Франц Улсын төслийн ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөгчид захиалагчтай хамтран ажиллах, төслийн хэрэгжилтийг түргэвчлүүлэх зорилгоор Улаанбаатар хотод 2021.09.20-2021.09.26-ны</p>

<p>хооронд ажилласан. Агаарын дүүжин тээврийн батлагдсан трассын дагуу Ханын материал, Баянхошуу, Гэмтлийн эмнэлгийн автобусны зогсоолуудаар дайран өнгөрч байгаа 22 чиглэлийн нэг сарын зорчигч урсгалын тоон мэдээллийг зорчигчийн төрлөөр ангилан гаргаж тооцоо судалгаа хийсэн. 2021.11.15-ны өдөр Нийслэлийн Засаг Даргын А/900 дугаар захирамж гарч 7 багц төслийн ажлын даалгавар боловсруулж, сонгон шалгаруулалт явагдаж, гүйцэтгэгч байгууллага шалгарч, тус байгууллагын зүгээс захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна.</p>						<p>4. Хийн түлшийг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх туршилт явуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа хийх</p>	<p>Туршилт судалгаа хийгдсэн байна.</p>	<p>2016</p>	<p>70%</p>	<p>Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд үндсэн чиглэлийн үйлчилгээний 1263 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас байгалийн шахсан хийн /CNG/ хөдөлгүүртэй 95 автобус буюу 7,5 хувь, таксин үйлчилгээний 503 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас шингэрүүлсэн шатдаг хийн LPG хөдөлгүүртэй 257 тээврийн хэрэгсэл буюу 51,1 хувийг тус тус эзэлж байна. Юу Би Метан ХХК нь 2018 оноос хойш Уул уурхай, Хүнд Үйлдвэрийн яамнаас олгосон байгалийн хий импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу БНХАУ, ОХУ-аас байгалийн шахсан /CNG/ хийг импортлож байна. Байгалийн шахсан хий түгээх үйл ажиллагаа 2020 оны 1,2 дугаар саруудад тасалдсантай холбогдуулан тус компанид 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 2/448 тоот албан бичгээр байгалийн шахсан хийгээр нийтийн тээврийн хэрэгслийг тасралтгүй хангаж ажиллах талаар мэдэгдэл хүргүүлж, өнөөдрийн байдлаар 95 автобусыг байгалийн шахсан хийгээр хангаж байна. "Юу Би метан" ХХК-иас 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 20/66 тоот бичгээр ОХУ-ын Төмөр замын тээвэр Ковид-19 нөхцөлтэй холбогдон удааширсан, БНХАУ-аас сүүлийн татан авалт Өвөр Монголын нутгаар аюултай ачаа тээвэрлэхийг хориглосон шалтгаанаар байгалийн шахсан /CNG/ хийн нийлүүлэлт тасалдаж байгаа</p>
---	--	--	--	--	--	---	---	-------------	------------	--

							<p>талаар манай газарт мэдэгдсэн. Тус газраас Ашигт малтмал, газрын тосны газарт 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр 2/1040 тоот албан бичгээр байгалийн шахсан /CNG/ хийгээр тасралтгүй хангуулах талаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр буурч байгаатай холбогдуулан Улаанбаатар хотод худалдаалагдаж буй дизель түлшний үнэ 1 литр нь 1760-аас 1320 төгрөг хүртэл буурсан ч байгалийн шахсан /CNG/ хийн 1м куб-ын үнэ 2150 төгрөгөөс буурахгүй байгаа тул зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд нь дизель хөдөлгүүртэй автобусыг нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд илүү ажиллуулж байна.</p>	<p>Хийн түлшийг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх туршилтыг хийж, бүртгэлийн санд 1263 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас байгалийн шахсан хийн /CNG/ хөдөлгүүртэй 95 автобус буюу 7,5 хувь, таксийн үйлчилгээний 503 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас шингэрүүлсэн шахсан хийн /LPG/ хөдөлгүүртэй 257 тээврийн хэрэгсэл буюу 51,1 хувийг тус тус эзэлж байна.</p>
5.	5. Дотоодод угсарч монбус, болон түлшний төхөөрөмж суурилуулсан тээврийн хэрэгслийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлын үзүүлэлтийг шалгах төвийн ТЭЗҮ боловсруулж	Техникийн төвийн төв байгуулагдаж, зорчигчдын аюулгүй байдал хангагдсан байна.	100%				<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Нийслэлийн нийтийн тээвэрт байгаль орчинд ээлтэй цахилгаан автобус нэвтрүүлэх, туршилт хийх тухай" 122 дугаар тогтоолоор 939,444,0 мянган төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргаж, "МОН-30" загварын их багтаамжийн цахилгаан автобус 2 ширхэгийг дотооддоо үйлдвэрлэж, үйлчилгээнд явах боломжтой судалгааны дүнг гарсан. Дүнг Засгийн газрын 2019 оны 26 дугаар хуралдаанд танилцуулж, Зам тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөл 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж, шийдвэрээ зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн "Орон нутгийн өмчид шилжүүлэх тухай" 01/3912 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. Тус</p>	

									газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/68 тушаалаар МОН-30 загварын их багтаамжийн 2 ширхэг цахилгаан автобусыг акт үйлдэн хүлээн авч, 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/74 тушаалаар "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн. Дотооддоо 2 троллейбусыг угсарч үйлдвэрлэн үйлчилгээнд гаргасан.
--	--	--	--	--	--	--	--	--	---

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

З.ЦЭВЭЭНДОРЖ



НЭГТГЭСЭН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРЦЭЦЭГ

